



MDS KhanLex

- “Манай удирдах зөвлөлийнхөнд [ЭмДиЭс ХаанЛекс] хуулийн нөхөрлөл маш тааламжтай сэтгэгдэл төрүүлсэн. Тэдний шуурхай үйлчилгээ, мөн Монголын бизнес, улс төрийн нөхцөл байдалд хандах хандлага, дүгнэлтэд нь бид итгэл дүүрэн байдаг.”
- “[ЭмДиЭс ХаанЛекс]-ийн хуульчид нь өндөр ур чадвар эзэмшсэн, ихэнх нь Англи хэлээр маш сайн ярьдаг.”
- “[ЭмДиЭс ХаанЛекс]-ийн хуульчид нь үйлчлүүлэгчдийн хүсэлтэд цаг тухайд нь хариулж, шуурхай үйлчилдэг.” **Chambers and Partners Asia-Pacific Guide 2017**

“ЭмДиЭс ХаанЛекс” ХХН (хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл) нь өөрийн эрхэлж байгаа онцлог үйл ажиллагааныхаа хувьд Монгол Улс дахь хамгийн том, олон гишүүнтэй хуулийн нөхөрлөл юм. Энэхүү нөхөрлөл нь “Эм Ди Эс Ассошэйтс” болон “ХаанЛекс Адвокэйтс” хоёр ЗБН (зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл)-ийн нэгдлийн үр дүнд байгуулагдсан.

Бид өөрсдийн ажлын арвин их туршлага, олон улсын эрх зүйн мэдлэгтээ түшиглэн үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Ингэхдээ бид үйлчлүүлэгчийнхээ бизнесийн хэрэгцээ, шаардлагыг ойлгож ажиллах талаар маш их анхаарал тавьж, тэдний нөхцөл байдалд нийцэх бодит шийдлийг олж чаддаг.

Манай үйлчлүүлэгчид нь Төрийн Өмчит Компани, төрийн байгууллагуудаас эхлэн, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн томоохон компаниуд байдаг. Тухайлбал, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк, Хилийн чанад дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын корпорац (ОРИС),

Майкрософт Корпорац, ZTE Монгол, Хаан Банк, Санхүүгийн Зохицуулах Хороо, хэд хэдэн яам, Монголын хөрөнгийн бирж зэргийг нэрлэж болно. Үүнээс гадна Baker McKenzie, Norton Rose Fulbright, Milbank зэрэг олон улсын хуулийн фирмийн хүсэлтээр гол төлөв Монгол Улсын үндэсний эрх зүйн зохицуулалт, практикийн асуудлаар зөвлөгөө өгч, хамтран ажилладаг.

Урт удаан хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэн хөгжиж байгаа олон улсын томоохон хуулийн фирмүүд болох Clyde & Co LLP, Sidley Austin LLP-тэй тус нөхөрлөлийн эхлүүлсэн хамтын ажиллагаа нь бидний мэргэжлийн ур чадварыг улам сайжруулж, олон улсын стандартад нийцсэн эрх зүйн зөвлөх үйлчилгээг Монгол улсад нэвтрүүлэх боломж олгож, хууль зүйн хил дамнасан асуудлыг шийдвэрлэх бидний давуу талыг тодорхойлдог.

ЭмДиЭс ХаанЛекс ХХН-ийг хууль эрх зүйн салбарын тэргүүлэх Legal500 болон AsiaLaw хэвлэлүүд хүлээн зөвшөөрч, санал болгож буй хуулийн фирмүүдийн төвшинд үнэлсэн нь манай мэргэжилтнүүдийн туршлага, амжилтуудыг батлан харуулж байна.

Үндсэн үйл ажиллагаа ба салбарууд

Бид дараахь чиглэлээр эрх зүйн бүрэн үйлчилгээ үзүүлдэг:

- | | |
|---|------------------------------|
| * Компанийн эрх зүй | * Хууль тогтоомж |
| * Компанийн Нэгдэл ба Худалдан Авалт (M&A) | * Хөрөнгийн зах зээл |
| * Төр, хувийн хэвшлийн түншлэл / Төслийн санхүүжилт | * Үл хөдлөх хөрөнгө/ Барилга |
| * Эрчим хүч/Газрын тос | * Уул уурхай |
| * Байгалийн хий | * Дэд бүтэц |
| * Банк санхүү | * Маргаан шийдвэрлэх |
| | * Оюуны өмч |



Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН нь хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг ойлгож хамгийн ярвигтай асуудалд ч мэргэжлийн шийдлийг олдог хуульчидтай тус улсын хамгийн том мэргэжлийн хамт олон юм.

The Legal 500 Asia Pacific 2018